



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯН-АДАРГА СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 08 сарын 07 өдөр

Дугаар А/76

Баян-Адарга сум

**Хонины цэцэг өвчнөөс сэргийлэх
хоёрдугаар тунгийн дархлаажуулалтын
ажлыг зохион байгуулах тухай**

Монгол Улсын "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль"-ийн 66 дугаар зүйлийн 66.1, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5, 6.6, 9 дүгээр зүйлийн 9.4, 9.5, 9.6, 9.7 дэх заалт, Мал эмнэлгийн Ерөнхий газрын даргын 2025 оны А/239 тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус суманд 2025 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр гоц халдварт хонины цэцэг өвчин оношлогдож Баян-Адарга суманд гоц халдварт хонины цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын анхдагч тун хийгдсэн хоёрдугаар тунгийн дархлаажуулалтын ажлыг 2025 оны 08 дугаар сарын 07-ны өдрөөс 18-ны өдрийн хүртэл 11 хоногт шуурхай зохион байгуулсугай.

2. Дархлаажуулалтад шаардлагатай вакцин, мэргэжил арга зүйн заавар зөвлөмжөөр хангах, явцын болон гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах, урьдчилан сэргийлэх, дархлаажуулалтын мэдээ тайлан, тушаалын хэрэгжилт, үр дүнг танилцуулж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн тархвар зүйч (Б.Баярцэцэг)-т, заасан хугацаанд мал үлдээлгүй дархлаажуулахыг Гүндаа авшиг ХХК мал эмнэлгийн малын эмч Д.Оюунчимэг, Онон дуурлиг ХХК мал эмнэлгийн малын эмч Ц.Нарантуяа нарт үүрэг болгосугай.

3.Малчдад урьдчилан мэдэгдэж тарилгын хашаа, хоолойг бэлдүүлэн, зарлан мэдээлэл хүргэж, хяналт тавьж ажиллахыг багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Урьдчилан сэргийлэх шуурхай дархлаажуулалтад хугацаандаа мал сүргээ бүрэн хамруулаагүй, хамруулахаас зайлсхийсэн малчид, мал бүхий иргэд, заавар журмыг баримтлаагүйн улмаас малын өвчин гарах нөхцөлийг бүрдүүлсэн албан тушаалтанд хуулийн дагуу хариуцлага тооцож ажиллахыг Мал эмнэлгийн Тасгийн тархвар зүйч (Б.Баярцэцэг)-т үүрэг болгосугай.

7.Дархлаажуулалтад ажиллах хүн хүч, машин техник, шатах тослох материалын бэлэн байдлыг ханган ажиллахыг Засаг даргын тамгын дарга (С.Бат-Эрдэнэ)-д даалгасугай.

8.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Орлогч (Н.Ганбат)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  ОЛХАГВАДОРЖ